

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН
2017 ОНЫ 7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.08.03

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 07 дугаар сард 2 удаа хуралдаж 16 асуудал хэлэлцэж 13 тогтоол баталлаа. Үүнд:

-Ардын хувьсгалын 96 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах баяр наадмын төсөв, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, аймгийн нутаг дэвсгэрээс 2017 онд ойгоос нэмэлтээр бэлтгэх модны дээд хязгаар тогтоох тухай болон олон жил ашиглагдаж элэгдлээ бүрэн нөхсөн зарим байгууллагын тээврийн хэрэгслийг үндсэн байгууллага, аймгийн Засаг дарга, орон нутгийн өмчийн газрын саналыг тус тус үндэслэн актлах, дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч дуудлага худалдааны доод үнийг хэлэлцэн тогтоол гаргасан. Мөн зарим байгууллагын хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Баянгол сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй үндсэн хөрөнгийг сумын спорт цогцолборын үндсэн хөрөнгөд, Жавхлант, Шаамар сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 04-ийн шугам, дэд станцыг Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-д шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хурлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийг хэлэлцэн баталсан бөгөөд уг хөтөлбөр нь 2017-2023 онд 2 үе шаттайгаар хэрэгжинэ.

-Нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласныг нь үнэлж О.Буянтогтох, Ж.Санжжав нарыг Сэлэнгэ аймгийн дээд шагнал “Сэлэнгэ аймгийн хүндэт иргэн”-ээр өргөмжлөн шагнаж, олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг нь үнэлж Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг Монгол Улсын цол, одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн дахин санал хураалтын ажиллагааг тогтоосон хугацаанд зохион байгуулж, аймаг, сумдын сонгуулийн хороонд нийт 89 хүн, санал авах 58 байранд 406 хүн ажиллаж, сонгуулийн санал хураалтын явцын болон эцсийн дүн мэдээг холбогдох заавар, журмын дагуу Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэн ажилласан.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Ардын хувьсгалын 96 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн үндэсний их баяр наадмыг энэ сарын 10, 11-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд хүчит 256 бөх хүч үзэн барилдаж, аймгийн хурц арслан Эрдэнэжавын хүү Саранбаатар түрүүлж, аймгийн начин Д.Төрболд үзүүрлэлээ. Наадмын хурдан морины азаргын уралдаанд Алтанбулаг сумын Баярцэнгэлийн хул магнайж, Ерөө сумын Одсүрэнгийн ягаан, Мандал сумын Баярболдын хүрэн, Баянгол сумын Батжаргалын саарал, Түшиг сумын Дашзэвэгийн хээр, Их насны түрүү магнайд Алтанбулаг сумын Эрдэнэ-Очирын хар хурдалж, Сүхбаатар сумын Энхсүхийн цоглог хээр, Мандал сумын Пүрэвдоржийн бор, Хушаат сумын Бат-Очирын хул, Сүхбаатар сумын Мөнхбатын хонгор халзан, хурдан соёолонгийн түрүү магнайд Баянгол сумын Бадрал-Эрдэнийн зээрд хурдалж, Сүхбаатар сумын Очирзаяагийн халтар, мөн сумын Батзулын хүрэн, Баянгол сумын Нямын хүрэн, Мандал сумын Баяртулгын хүрэн, хязаалан насанд Түшиг сумын Эрдэнэмандахын ягаан бор түрүүлж, Сүхбаатар сумын Ган-Эрдэнийн хонгор, Шаамар сумын Энхсайхны хар, Сайхан сумын Тулгын зээрд, Баянгол сумын Мөнхтулгын хонгор, шүдлэн насанд Хушаат сумын Алтансүхийн хээр алаг түрүү магнайд хурдалж, Алтанбулаг сумын Эрдэнэ-Очирын шарга халзан, мөн сумын Ганболдын хүрэн,

Шаамар сумын Энхсайханы уран бор, Цагааннуур сумын Мөнх-Эрдэнийн хээр, дааганы түрүү магнайд Зүүнбүрэн сумын Ганбаатарын сартай хүрэн хурдалж, Сүхбаатар сумын Баянмөнхийн хар аман хүзүүдэж, Зүүнбүрэнгийн Сүрэнжаргалын хүрэн, Түшигийн Эрдэнэмандахын бор, мөн сумын Сүрэнхүүгийн хүрэн халзан тус тус айрагдлаа. Сурын харваа үндэсний сур, буриад сур, урианхай сур гэсэн 3 төрлийн харваагаар мэргэчүүл маань онч мэргэнээ сорин өрсөлдлөө. Эмэгтэйчүүдийн тэргүүн байрт Дархан-Уул аймгийн харваач Б.Уугантуяа, эрэгтэйчүүдийн харваанд Д.Дарханбат, Урианхай сурын харвааны эрэгтэйчүүдийн тэргүүн байрт Сүхбаатар сумын уугуул Алдар спорт хороо, Зэвсэгт хүчний 331-р ангийн залуу харваач М.Баярсайхан, Буриад сурын харвааны эрэгтэйчүүдийн тэргүүн байрт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн “Алтан дуулга” багийн харваач спортын мастер П.Гармаа, эмэгтэйчүүдийн харваанд Сүхбаатар сумын харваач спортын мастер, МУ-ын гарамгай харваач О.Ваанчигмаа нар тэргүүн байрыг эзэллээ.

Аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд гадаадын олон зочид төлөөлөгчид уригдан ирсэн бөгөөд Кувейт Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Халид Яатийм АльФадли өөрийн биеэр хүрэлцэн ирж аймгийн Нэгдсэн эмнэлэгт 200,0 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, иж бүрэн тоноглол бүхий 300,0 сая төгрөгийн өртөгтэй яаралтай түргэн тусламжийн хоёр ширхэг автомашиныг аймгийн нэгдсэн эмнэлэг болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт гардуулан өглөө.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2017 оны А/326 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийг гаргаж, ажлын хэсэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд оролцож, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлэх ажлыг эхлүүлсэн.

Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын дагуу Төвийн бүсийн Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг Батлан хамгаалахын сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээ, Батлан хамгаалах яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын 2017 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/252 дугаар захирамжийн дагуу 2017 оны 07 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд тус аймгийн Алтанбулаг сумын нутагт байрлах “Гүн нуур” зуслангийн материаллаг баазыг түшиглэн амжилттай зохион байгуулж явууллаа. Сургалтын зорилго нь сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт шинээр батлагдан гарсан Батлан хамгаалахын бодлого, хууль тогтоомжийн талаар танилцуулж, тэдний орон нутагт энэ чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож нэгдсэн ойлголтонд хүрэх, орон нутгийн удирдлагаас гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн, дээд шатны байгууллагыг бодит мэдээ, мэдээллээр хангах зорилготой бөгөөд төвийн бүсийн 7 аймгийн 102 сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар тус сургалтад хамрагдах ёстойгоос 84 хүн /эрэгтэй-45, эмэгтэй-39/ буюу 85 хувь нь оролцсон байна.

Онцгой байдлын талаар:

Аймгийн Онцгой байдлын газраас 2017 онд “Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай” хууль тогтоомж, Монгол Улсын Шадар сайд, ОБЕГ-ын даргын тушаал шийдвэр, үүрэг даалгавар, аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хангах, гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, Онцгой байдлын ерөнхий газар, Онцгой байдлын газраас 2017 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг хангах, сахилга хариуцлагыг сайжруулах талаар дараах ажлыг зохион байгууллаа.

Баяр наадмын талбайд худалдаа үйлчилгээ явуулж байгаа 20 аж ахуйн нэгж байгууллага иргэдэд гал түймэр гамшиг ослоос урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гамшиг, осол, гал түймэр гарч болзошгүй 56 зөрчил дутагдлыг илрүүлж зөрчлийг арилгуулахаар мэдэгдэл 12, Заавал биелүүлэх албан шаардлага 6-г гаргаж, дарга эрхлэгч нарт танилцуулан шалган зааварчилж ажилласан.

“Баяр наадам” амралтын өдрүүдэд голын эрэг дагуу ард иргэдэд урьдчилан сэргийлэх эргүүл шалгалт хийсэн байдал

| Үзүүлэлт | Үзлэг шалгалтанд хамрагдсан | | Зөрчил | | Бичсэн эрх зүйн бичиг баримт | | | | | | Хянасан зураг төсөл | |
|-------------------|-----------------------------|---------|-----------|-------------|------------------------------|----------|-------------|---------|-----|-----------|---------------------|---|
| | ААНБ | Айл өрх | Илрүүлсэн | Арилгуулсан | ЗБАШ | Мэдэгдэл | Танилцуулга | Дүгнэлт | Акт | АЗТогтоол | | |
| Он | | | | | | | | | | | | |
| 2016 оны 07-р сар | 42 | - | 106 | 26 | 13 | 31 | - | - | 1 | 1 | - | - |
| 2017 оны 07-р сар | 20 | | 56 | 8 | 6 | 12 | | 1 | 3 | - | 2 | |

2017 оны 07 дугаар сард 8 удаагийн объектын гал түймэр гарснаас 1 гал түймэр мэдээллээр ирж 7 гал дээр Аврах, гал унтраах анги ажиллаж унтраасан. Гарсан 8 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 3 үйлдэж шийдвэрлэсэн, 3 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдсэн байна. Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны угсралтын буруугаас 2, ил задгай үнс нурам асгасанаас 2, пийшин зуух яндангийн цонолтоос 4 удаа тохиолдсон байна.

Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

| д/д | Гал түймрийн төрөл | 2016 оны 7 дугаар сар | 2017 оны 7 дугаар сар | Өссөн, буурсан |
|-----|--------------------|-----------------------|-----------------------|----------------|
| 1 | Объектын | 4 | 8 | 4-өөр өссөн |

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэнээс гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр-1, сонинд-1 удаа мэдээ явуулсан.

Орхон болон Сант сумын ЗДТГ-тай хамтран “Гол мөрний усанд осолдохоос сэргийлье” сэдэвт нэгдсэн арга хэмжээний хүрээнд удирдамж боловсруулан баталж Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн 2017 оны 07-р сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарыг дуустал хугацаанд Орхон сум, Сант сум, Орхон голын гүүрний эрэг дагуу болон Оросын тохой, Орхон сумын төв хүртэлх газруудаар завьт эргүүл хийж, амарч аялж буй ард иргэдэд гол усанд осолдохоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөө өгч, сэрэмжлүүлэг материал тарааж, эргүүл шалгалтыг тогтмол хийж байна. 2017 оны 7 дугаар сар 20-ны байдлаар давхардсан тоогоор 1260 том хүн, 540 бага насны хүүхэд, 450 тээврийн хэрэгслийн жолооч нарт анхаарал болгоомжтой байх талаар зөвлөгөө өгсөн.

Мөн Онцгой байдлын газрын даргын 2017 оны “Албаны өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг томилох тухай” А/21 дүгээр тушаалаар нийт бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгэх шуурхай удирдлагын зохицуулагч нарыг томилгоожуулсан.

Албаны өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах хугацаанд Онцгой байдлын хэлтэс, ангийн хэмжээнд хариуцлагатай жижүүр, үүрэг гүйцэтгэх шуурхай бүлгийг томилж, яаралтай цугларалтын хуваарь, хаягийн бүртгэлд тодотгол хийж, машин техник, багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж автомашины шатахууны дүүргэлтийг 80 хувиас доошгүй байлгаж, бие бүрэлдэхүүний ажлын хариуцлага, сахилга, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж, үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, ерөнхий эргүүл, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид тухай бүр танилцуулж, Цаг уурын хэт халалт, хуурайшилтын нэн аюултай түвшинд хүрч ой, хээрийн түймэр гарах эрсдэл их байгаатай холбогдуулан шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж, амралттай байгаа албан хаагчдыг дуудан ажиллуулж, түймэр гарах эрсдэл бүхий газруудад аялал зугаалгыг түр хугацаагаар хориглох, хяналтын цэг, гэрээт харуулыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан.

ОБЕГ-ын даргын “Үүрэг хүргүүлэх тухай”1/1389 дугаар албан үүргийг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж, ОБГ-ын даргын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 31/239 дугаар албан зөвлөмжийг 17 сумын ЗДТГ-т хүргүүлсэн. Мөн болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээ мэдээлэл, шуурхай мэдээг орон нутгийн “Миний Монгол” КаТВ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, Сайхан сумын Эрдэнэ КаТВ-ээр “Усанд осолдхоос сэргийлье”, “Үер усны аюулаас сэргийлье” гэсэн сэрэмжлүүлгийг 2017 оны 07 сарын 09-ний өдрөөс, 07 сарын 18-ны өдрүүдэд өдөрт 3 удаагийн давтамжтайгаар явуулж, ард иргэдэд хүргүүлж сэрэмжлүүлэг өгч ажилласан.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Увс аймгийн Улаангом хотноо 2017 оны 07 сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Стандарт, хэмжил зүйн салбарын улсын нэгдсэн зөвлөгөөнд тус хэлтсийн хамт олон оролцож, салбарын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл авч, санхүү, стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорьцын хяналтын чиглэлээр сургалтанд хамрагдаж, спортын тэмцээн, уралдаанд оролцсон. Мөн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2017 оны 06 сарын “Олон улсын сургалтанд оролцуулах тухай” А/185 тоот тушаалын дагуу тус хэлтсийн баталгаажуулалтын ахлах шинжээч энэ оны 07 сарын 07-27-ны өдрүүдэд БНХАУ-ын Жангсу мужийн Чанг Жеү хотод БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулж буй “2017 оны хөгжиж буй орнуудын стандартчилал хамтын ажиллагаа” олон улсын сургалтанд хамрагдсан.

Алтанбулаг сумын нутагт байрлах "Гүннуур" зуслангийн үйл ажиллагаанд "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага MNS 5633:2013" стандартын дагуу аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт, хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтнүүд хамтарсан үзлэг шалгалт, тохирлын үнэлгээ хийж, зөвлөмж өгч, Сүхбаатар сумын 4 худалдаа үйлчилгээний газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгосон.

“Нарны Соронзон” ХХК-ий 1 ш хэмжих хэрэгсэл, “Болд Төмөр Ерөө гол” ХХК-ий Баянгол уурхайн үйл ажиллагаанд ашиглагддаг хүнд даацын автомашины /100 т/ 3ш жинг баталгаажуулалтанд хамрууллаа.

Эзэлхүүн хэмжлийн лабораториос “Сод Монгол” ШТС 84-ын 2 түгээгүүрийг шалган, баталгаажуулалтанд, цахилгааны хэмжлийн лабораториос цахилгааны нэг фазын 8 ш тоолуурыг шалган баталгаажуулсан.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

07 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Сангийн яамтай хамтран 2018 оноос хэрэгжиж эхлэх Төрийн сангийн шинэ програмын сургалтыг сумын Санхүүгийн алба болон төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 100 хүн оролцсон бөгөөд шинэ програмыг турших, дадлага олгох зорилготой бөгөөд 2018 оноос хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Татварын хөнгөлөлт, буцаан олголтын материал хүлээн авсан гүйцэтгэлээр нийт 2302 иргэнд 1,116.0 сая төгрөг олгохоор гарсан бөгөөд төсвийн орлоготой уялдуулан 7 дугаар сард бүрэн олгож дууслаа.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 3-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг www.selenge.nso.mn хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

| Д/Д | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|--------------|--|--------------|--------------|-------|
| 1 | Орон нутгийн төсвийн нийт орлого | 9,481,777.3 | 11,728,050.9 | 123.7 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 6,648,635.1 | 5,928,171.9 | 89.2 |
| 2 | Орон нутгийн төсвийн нийт зарлага | 45,343,024.3 | 37,676,091.1 | 83.1 |
| | - Аймгийн төсвийн зарлагын дүн | 11,738,097.2 | 9,106,344.2 | 77.6 |
| | - Аймгийн ОНХСангийн зарцуулалт | 338,420.7 | 282,497.8 | 83.5 |
| | - Аймгийн авто замын хөрөнгө оруулалт | 548,578.5 | - | 0.0 |
| | - Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | 1,626,976.1 | 210,182.4 | 12.9 |
| 3 | Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг | 1,321,883.0 | 792,847.6 | 60.0 |
| 4 | Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг | 2,000,000.0 | 2,000,000.0 | 100.0 |
| 5 | Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 25,029,373.7 | 25,029,373.7 | 100.0 |
| | - Ерөнхий боловсролын сургууль | 13,030,936.4 | 13,030,936.4 | 100.0 |
| | - Хүүхдийн цэцэрлэг | 6,797,328.5 | 6,797,328.5 | 100.0 |
| | - Соёлын байгууллага | 1,564,866.3 | 1,564,866.3 | 100.0 |
| | - Биеийн тамир спортын байгууллага | 553,013.0 | 553,013.0 | 100.0 |
| | - Эрүүл мэндийн байгууллага | 2,802,633.6 | 2,802,633.6 | 100.0 |
| | - ГХБХБГазар | 114,116.7 | 114,116.7 | 100.0 |
| - ГБХЗХГазар | 166,479.2 | 166,479.2 | 100.0 | |
| 6 | Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 25,029,373.7 | 25,029,373.7 | 100.0 |
| | - Ерөнхий боловсролын сургууль | 13,030,936.4 | 13,030,936.4 | 100.0 |
| | - Хүүхдийн цэцэрлэг | 6,797,328.5 | 6,797,328.5 | 100.0 |
| | - Соёлын байгууллага | 1,564,866.3 | 1,564,866.3 | 100.0 |
| | - Биеийн тамир спортын байгууллага | 553,013.0 | 553,013.0 | 100.0 |
| | - Эрүүл мэндийн байгууллага | 2,802,633.6 | 2,802,633.6 | 100.0 |
| | - ГХБХБГазар | 114,116.7 | 114,116.7 | 100.0 |
| - ГБХЗХГазар | 166,479.2 | 166,479.2 | 100.0 | |
| 7 | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 1,698,030.1 | 1,698,030.1 | 100.0 |

| | | | | |
|----|--|-----------|-----------|-------|
| 8 | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 1117955.1 | 1115755.5 | 99.8 |
| 9 | Аймгийн нийт ангилагдаагүй зардал | 469,937.0 | 469,937.0 | 100.0 |
| 10 | Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц | 314,100.3 | 314,100.3 | 100.0 |
| 11 | Тусгай сангуудын зарлага | 616,361.9 | 145,883.8 | 23.7 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | | 2017 V- сар | 2017 VI- сар | $\frac{2017-VI}{2017-V}$ /төгрөгөөр/ |
|--|--------------------------------------|----------------|-----------------|---|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | | |
| 1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | | | | |
| | Гурил /савласан, кг/ | 1250 | 1 250 | |
| | Талх /орон нутгийн, ш/ | 1100 | 1 100 | |
| | Нарийн боов /кг/ | 2150 | 2 200 | +50 |
| | Будаа /кг/ | 2500 | 2 400 | -100 |
| | Элсэн чихэр /кг/ | 2300 | 2 300 | |
| 2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | | | | |
| | Хонины мах /кг/ | 6500 | 6 000 | -500 |
| | Үхрийн мах /кг/ | 7800 | 7 500 | -300 |
| | Адууны мах /кг/ | 6000 | 6 000 | |
| | Ямааны мах /кг/ | 5000 | 5 000 | |
| | Дотор мах, цувдай /цусгүй/ | 3000 | 3 000 | |
| | Хиам /чанасан, кг/ | 10000 | 10 000 | |
| 3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | | | | |
| | Сүү /задгай, л/ | 1200 | 800 | -400 |
| | Сүү / савласан, л/ | 2500 | 2 500 | |
| | Тараг /задгай, л/ | 2500 | 1 200 | -1 300 |
| | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 13000 | 13 000 | |
| | Айраг /л/ | 3500 | 3 500 | |
| | Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 4000 | 4 000 | |
| | Өндөг /ш/ | 300 | 320 | +20 |
| 4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС | | | | |
| | Ургамлын тос /л/ | 3800 | 3 800 | |
| | Өөхөн тос /кг/ | 1800 | 1 800 | |
| | Шар тос /кг/ | 10000 | 10 000 | |
| | Масло /задгай, кг/ | 4000 | 4 000 | |
| 5 ХҮНСНИЙ НОГОО | | | | |
| | Төмс /кг/ | 600 | 750 | +150 |
| | Лууван /кг/ | 500 | 1 100 | +600 |
| | Манжин /кг/ | 1000 | 1 000 | |
| | Байцаа /кг/ | 1300 | 1 500 | +200 |
| | Сонгино /кг/ | 1500 | 1 500 | |
| | Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 3300 | 3 300 | |
| | Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/ | 2600 | 2 600 | |
| 7 ШАТАХУУН | | | | |
| | Бензин А - 80 | 1480 | 1 480 | |
| | Бензин А - 92 | 1630 | 1 630 | |
| | Дизелийн түлш | 1720 | 1 720 | |

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Аймгийн хэмжээнд 2017 оны 6 дугаар сард 328 холбогдогчтой, 627,9 сая төгрөгийн хохиролтой, 289 гэмт хэрэг бүртгэгдэж, 32 хэргээр буюу 10,0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 6-р баг, Дулаанхаан тосгон, Алтанбулаг, Зүүнбүрэн, Хушаат, Баянгол, Орхон сумдад 11,1-66,7 хувиар, СБ сум 7-р баг, Хүдэр суманд 2.2-2,8 дахин өсч, Сүхбаатар сумын 2, 3, 4, 5, 8-р баг, Бугант тосгон, Шаамар, Жавхлант, Цагааннуур, Түшиг, Мандал, Сайхан, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумдад 8,2-66,7 хувиар, тус тус буурч, Сүхбаатар сумын 1-р баг, Ерөө суманд өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 7 дугаар сард 115 төрөлт, 14 гэрлэлт, 8 гэрлэлт цуцлалт, 33 нас баралт бүртгэгдэж, 616 иргэнд цахим үнэмлэх, 616 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 4368 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 49, шилжин ирсэн 21, сум дүүрэгт шилжин ирсэн 3, сум дүүрэгт шилжин явсан 5, баг хооронд шилжин ирсэн 17, баг хооронд шилжин явсан 18 шилжилт хөдөлгөөн бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 264 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 624 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 152,356 төгрөг, үйлчилгээний хураамжийн 14,531,718 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 15,101,600 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

2.Архивын талаар

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий гүйцэтгэсэн аймгийн Нэгдсэн эмнэлгийн доторх зам засварын ажлын гүйцэтгэл, “Жи Ти Кэй Эс” ХХК-ний гүйцэтгэсэн аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэнгийн саравч гүйцээх, стандартын таримал зүлэгтэй хөл бөмбөгийн талбай барих ажлын гүйцэтгэлийн баримт бичгийг хүлээн авч акт, бүртгэл үйлдэж хөмрөгт байрлуулсан.

Баримтыг цахимд шилжүүлэх төлөвлөгөөний дагуу Зүүнхараа хотын Спиртын үйлдвэрийн 1970-1998 оны 18 хадгаламжийн нэгж, Номгон ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль 1977-2016 оны 40 хадгаламжийн нэгж, Эрүүл мэндийн газрын 1970-1981 оны хадгаламжийн нэгж, Мандал сумын "Цант-Орхон" ХХК 1999-2012 оны 13 хадгаламжийн нэгж, Дулаанхаан тосгоны Соёлын төв 2009-2015 оны 7 хадгаламжийн нэгж, Алтанбулаг сумын Соёлын төв 2003-2015 оны 11 хадгаламжийн нэгж, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв 1985-2015 оны 31 хадгаламжийн нэгж, нийт 7 хөмрөгийн хадгаламжийн нэгжний мэдээллийн агуулгыг уншиж заалт-7564, хүний нэр-48514, байгууллагын нэр-2797, газар зүйн нэр-1582-ыг АМС программд шивж, эх баримттай нь холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн Зүүнхараа хотын Хүнсний үйлдвэр, Шаамарын ХАА-н техник мэргэжлийн сургууль, Материал техник хангамжийн удирдах газар, Сэлэнгийн долгио чуулгын дансыг ажлын хэрэгцээнд түр шилжүүлэн авч тооллогын ажилд ашиглан тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичгүүдийн бүрэн эсэхийг шалгаж хөмрөгийн баримтуудыг данстай нь нэг бүрчлэн тулгаж тоолон дутагдаж алга болсон баримтуудыг олж тэдгээрийн шалтгааныг тогтоох ажлыг хийж, Зүүнхараа хотын Хүнсний үйлдвэрийн 63 хадгаламжийн нэгж, Шаамар сумын ХАА-н техник мэргэжлийн сургуулийн 34 хадгаламжийн нэгж, Материал техник хангамжийн удирдах газрын 13 хадгаламжийн нэгж, Сэлэнгийн долгио чуулгын 42 хадгаламжийн нэгжид хуудас дугаарлах, баталгаа хуудас бичих зэрэг эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж хавтаслан нүүрний бичилт хийсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Элсэлтийн ерөнхий шалгалтын 1420 хүүхдийн батламжийг 06-р сарын 28-30 ны хооронд тарааж, 1151 хүүхэд хуваарь сонголтонд орохоор бүртгүүлсэн Хуваарь сонголыг 2017 оны 07 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд зохион байгуулж, их

дээд сургуулийн консерциумаас их дээд сургуулийн 1915 хуваарь тус аймагт ирснээс 367 хүүхэд хуваарь авлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын нийгмийн тухай мэдлэг, монгол хэлний хичээлээр 800 оноо авсан Түшиг сумын сургуулийн Д.Төгсжаргалант, Сүхбаатар сумын 4-р сургуулын Г.Номуундарь нарыг аймгийн Засаг даргаас тус бүр нэг сая төгрөгөөр, ШУТИС-ын Япон Монголын хамтарсан инженер технологийн дээд боловсрол төслөөс зохион байгуулсан шалгалтанд амжилттай оролцож тэнцсэн Б.Мөнхтогтох, Г.Билгүүн, Ц.Оюун-эрдэнэ нарт суралцах эрхийн бичгийг аймгийн Засаг дарга гардуулан өгсөн.

Жил бүрийн 6-р сарын 4 дэх долоо хоногийн ням гаригт Улсын хэмжээнд “Тамирчдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэхүү арга хэмжээг аймгийн төвд журмын дагуу зохион байгуулж, дугуйт тэшүүр, шагай няслах, агаарын теннис, кросс гүйлт гэсэн 4 төрлөөр явууж, давхардсан тоогоор 100 гаруй тамирчин хамрагдаж Монгол улсын Засгийн газрын шагнал “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” тэмдгээр Таеквондогийн холбооны багш дасгалжуулагч н.Алтантуяа, Биеийн тамир спортын газрын жижүүр сантехникч н.Доржсүрэн, Жү-до бөхийн холбооны Баянгол сумын биеийн тамирын багш н.Батболд нарыг Биеийн тамир спортыг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн шагнаж урамшууллаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 06-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 1139 байсан бол 118 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 78 ажлын байранд 67 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 193 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 997 болсон байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сайхан, Жавхлант, Хүдэр зэрэг сумдын шаардлага хангасан 51 өрхийг малжуулахаар холбогдох материалыг бүрдүүлж, орон нутгийн иргэдийг түр ажлын байраар хангах ажлын хүрээнд Орхонтуул сумын малын ванн барих, Жавхлант сумын тохижилтын ажилд 25 иргэнийг түр ажлын байраар ханган хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 6220.0 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулж Сант сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулийн хүсэлтээр 2 ахмад настан зөвлөгөө мэдээлэл өгч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 560.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.

Нийгмийн халамжийн сангаас 07 сарын байдлаар 28613 иргэнд 5,799,429,429 төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2585 иргэнд 2,206,362,420төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1383 иргэнд 544,007,150 төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1234 иргэнд 71,410,490 төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 3617 иргэнд 289,674,970 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 304 иргэнд 67,291,219 төгрөг
- Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 3245 эхэд 574,196,720 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 39 иргэнд 44,440,860 төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8316 иргэнд 1,113,040,000 төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 3719 иргэнд 253,815,600 төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 94 иргэнд 7,238,000 төгрөг
- Насны хишиг 4001 иргэнд 635,190,000 төгрөгийг тус тус олгосон байна.

3.Эрүүл мэндийн талаар

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх хурлыг Мандал, Сайхан, Ерөө, Сүхбаатар суманд 2017 оны 06 сарын 20-30, 7 сарын 04-ний өдрүүдэд тус тус бүсчилэн зохион байгуулж, 1 хүртэлх насны хүүхдийн

эндэгдлийн 5, 1-5 хүртэлх насны хүүхдийн 3, амьгүй төрөлтийн 2, нийт 10 тохиолдлыг хэлэлцэж, хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрт дүгнэлт гаргасан.

Аймгийн хэмжээнд элэгний В,С вирус илрүүлэх үзлэг, оношлогоог анхан шатны сум, тосгон өрхийн Эрүүл мэндийн төвүүдээс 18920 хүн хамруулахаас 15050 хүн хамруулж хамрагдалт 52 хувьтай байна.

2017 оны 1-р ээлжийн цэрэг татлагын эмч нарын үзлэгт хамрагдсан залуучуудын 42.9 хувь нь 2 болон түүнээс дээш хавсарсан өвчлөлтэй, эрхтэн тогтолцооны өвчлөлөө эмчлүүлээгүйн улмаас өвчин эмгэг архаг хэлбэрт шилжиж хүндэрсэн залуучууд байсантай холбогдуулан “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжье” аяныг зохион байгуулах тухай албан тоотыг сумдад хүргүүлж үзлэг оношилгоог 8 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Эрүүл мэндийн салбарын 2018 оны төсвийн төслийг нийт 32 нэгжээс нэгтгэн авч Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Ардын хувьсгалын 96 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллаж хурдан морины уралдаанд дээд, дунд, бага насны эрлийз их нас, азарга, соёолон, хязгаалан, шүдлэн, даага нийт 9 насны 366 морьд уралдаж, давхардсан тоогоор 132 хүүхэд оролцлоо.

Уралдаанч хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, эрүүл мэнд аюулгүй байдалд хяналт тавих, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс уралдааны зам талбай, гарааны тоног төхөөрөмж, хурдан морины уралдаанч хүүхдийн насны хязгаар, гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байдал, хамгаалалтын хувцас хэрэглэл /малгай, хантааз, өвдгөвч, тохойвч, гутал/-ийг бүрэн өмсгөх, эцэг эх асран хамгаалагчийн зөвшөөрөл авсан байдал зэрэгт хяналт тавих, уралдаанч хүүхэд, уяачыг маягтын дагуу бүртгэх, уралдаанд оролцож буй хүүхдийг эмнэлгийн машинтай дагах, мориноос унасан хүүхдийг эмчид үзүүлэх, гэмтлийн зэрэг тогтоон хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, уяач нарт хүлээлгэн өгч, даатгалын байгууллагуудад зуучлах, морины эзэн, уяач, эцэг эх, асран хамгаалагч, уралдаанч хүүхдүүдэд зөвлөмж, гарын авлагаар ханган, тэдэнд шаардлага тавьж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан. “Мөргөлдөөн гамшгийн үед хүүхдийг хүнд хөдөлмөрөөс хамгаалъя” уриан дор 06-р сарын 12-ноос 08-р сарын 12 хүртэл хоёр сарын аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж байна. Тус аяны хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг 5 удаагийн сургалт мэдээллийг давхардсан тоогоор 250 иргэнд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг 120 хүүхдэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Эрүүл мэндийн даатгалын санд төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл 956239,50 мянган төгрөг оруулах төлөвлөгөөтэйгээс 735842,80 мянган төгрөг орж биелэлт 77 хувьтай, тэтгэврийн даатгалын санд төлөвлөгөөгөөр 8989676,40 мянган төгрөг оруулахаас 10113901,11 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөөний биелэлт 113 хувьтай байна. Тэтгэврийн даатгалын сангаас 15773 тэтгэвэр авагчдад 29936,08 сая төгрөгийг олгож, тэтгэвэр тавьсан зардалд 3499,77 мянган төгрөг зарцуулсан. Тэтгэмжийн даатгалын санд 1129277,10 мянган төгрөг оруулахаас 1141758,81 төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 101 хувь, үүнээс 2885 даатгуулагчдад 290013,87 мянган төгрөгний хөдөлмөрийн чадвараа түр алдалт, 708 даатгуулагчдад 709656 сая төгрөгийн жирэмсэн болон амаржсаны, 222 даатгуулагчдад 222 сая төгрөгийн оршуулгын, нийт сангаас 2080609,1 мянган төгрөгийн тэтгэмжийг олгожээ.

Мөн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд 778807,3 мянган төгрөг оруулахаас 1166298,67 төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 150 хувь байгаа ба тайлант хугацаанд 296 тэтгэвэр авагчдад 528,16 сая төгрөгийн

тэтгэвэр, Үйлдвэрлэлийн ослийн тэтгэмж, сувиллын зардалд 19 даатгуулагчдад 12451,7 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, хиймэл эрхтэн протез, рашаан сувиллын зардалд 479,94 мянган төгрөг тус тус олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 4446506,60 мянган төгрөг оруулахаас 4091300,69 мянган төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 92 хувьтай, үүнээс 10 эмнэлэгт 2786,43 сая төгрөг, 30 эмийн санд 262500,62 мянган төгрөг зарцуулжээ.

Ажилгүйдлийн даатгалын санд 274940,00 төгрөг оруулахаас 257308,40 мянган төгрөг оруулж төлөвлөгөөний биелэлт 94 хувьтай байгаа ба тус сангаас тайлант хугацаанд 380 даатгуулагчдад 520,86 сая төгрөгний ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2017 оны 7 дугаар сарын 2, 3, 6, 16, 17, 21, 23-ны өдрүүдэд нийт сумдын нутгаар 0,0-34,0 мм, 1, 7, 9, 10, 11, 13, 22, 23, 25-ны өдрүүдэд зарим сумдын нутгаар 0,0-9,0 мм бороо орсон ба бусад хугацаанд хур тунадас ороогүй. 7 дугаар сарын 2, 3, 9, 11, 17, 21-ний өдрүүдэд салхи ширүүсч 8-13 м/сек, зарим үед түр зуур ширүүсч 16-21 м/сек хүрсэн. Бусад хугацаанд салхи баруун болон баруун хойноосоо 5-10 м/сек байв. Сарын I-р арав хоногийн эхэн, II-р арав хоногийн дунд үеэр дулаарч шөнөдөө 16-21 градус, өдөртөө 29-34 градус дулаан байв. Бусад хугацаанд шөнөдөө 10-15 градус, өдөртөө 25-30 градус дулаан байлаа. Энэ сарын хоёрдугаар 10 хоногийн байдлаар Сэлэнгэ мөрний усны түвшин, Сүхбаатар сумаар 262 см, Зүүнбүрэн сум орчмоор 221 см ОЖД-аас 27-69 см-ээр бага. Орхон голын усны түвшин Сүхбаатар сумаар 114 см, Орхон сум орчмоор 140см ОЖД-аас 31-98 см-ээр бага. Хэнтийн нуруунаас эх авдаг Ерөө голын усны түвшин Ерөө сумаар 260, Дулаанхан сум орчмоор 191 см ОЖД-аас 43-84 см-ээр бага, Хараа голын усны түвшин, Баянгол сум орчмоор 141 см ОЖД-аас 33 см-ээр бага, Хүдэр голын усны түвшин Хүдэр сум орчмоор 196 см ОЖД-аас 23 см-ээр бага, Зэлтэр голын усны түвшин Түшиг сум орчмоор 244 см ОЖД-аас 15 см-ээр бага. Аймгийн голуудын усны түвшин цаашид үргэлжлэн буурах хандлагатай байна.

Аймгийн хэмжээнд 6-р сард улаанбуудайн соёололтын үзүүлэлтээр үр тарианы соёололт нийт тариалсан талбайн хэмжээнд авч үзвэл 9,9 хувь нь онц, 61,4 хувь сайн, 28,5 хувь нь дунд соёололттой байсан боловч 6-р сарын дунд 10 хоногоос 7-р сарын эхний 10 хоногт аймгийн хэмжээнд олон өдөр дараалан халсны улмаас бэлчээр хадлангийн болон таримал ургамлын ургалт удааширч, үр тарианы таримлын бутлалтаас гол хатгалтын үед халалт ихээр явагдсанаас улаанбуудайн ишний өндөр, тариан түрүү богино болж механик болцонд орж, ихэн аж ахуйн нэгжүүдийн улаанбуудай түрүүлсэн зарим талбай нь цэцэглэлтийн үе шатандаа орсон байна.

7-р сарын 11-нд Шаамар суманд байгаль цаг уурын онц аюултай үзэгдлийн улмаас тус сумын 130 өрхийн төмс, хүсний ногооны 79,9 га талбай мөндөр цохиулсанаас төмс, 10,1 га, байцаа-6.51 га, лууван-19.9 га, шар манжин-3.26 га, улаан манжин-3.04 га, сонгино-8.96 га, сармис-2.11 га, өргөст хэмх-3.23 га, улаан лооль-2.86 га, тарвас-18.63 га, чинжүү-0.105 га бусад- 0.9 га талбай эзэлж байна.

Энэ намрын ургац хураалтанд ажиллах үр тарианы комбайн 454, ангилангийн жатка 173, төмсний комбайн 22, төмс ухагч 28, төмс сортлогч 9, будаа цэвэрлэгч 180, үр сортлогч 70, будаа ачигч 128, механикжсан үтрэм 14, буюу нийт ажиллах техникийн 93.2 хувь, мөн хадлан тэжээл бэлтгэлтэнд дугуйт трактор 304, бага оврын трактор 174, тракторын хадуур 239, тракторын тармуур 209, хаман боогч 86, нуруулдагч 9, морин хадуур, тармуур 187, ширхэг ажиллах буюу 35.1 хувь нь засвар үйлчилгээ хийсэн мэдээтэй байна.

Мах сүүний анхдугаар аяны хүрээнд “Монгол драймилк” ХХК-тай хамтран Ерөө, Зүүнбүрэн суманд хуурай сүүний үйлдвэр байгуулах ажлын бэлтгэлийг бүрэн хангаад байна.

ХХААХҮЯ, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Ногоон алт, малын эрүүл мэнд” төслөөс хамтран зохион байгуулсан бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх, таатай орчин бүрдүүлэх талаар хийсэн сургалт, зөвөлгөөнийг энэ сарын

25-ны өдөр Сүхбаатар суманд зохион байгуулж, сургалтанд Цагааннуур, Алтанбулаг, Орхон, Орхонтуул, Баянгол сумдын 25 хүн хамрагдлаа.

Сүхбаатар, Мандал, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 15 эмгэгт дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг холбогдох мал эмнэлгийн нэгж, иргэдэд өгсөн. Мөн ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар, Зүүнбүрэн, Шаамар сумын 283 мал амьтанд бруцеллёз, боом, нийлүүлгийн өвчин, ям, адууны халдварт цус багадах өвчний шинжилгээ хийж эрүүл болохыг баталгаажуулж хариуг олгосон.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос баталсан “Шүлхий, бог малын мялзан өвчний халдварын болон вакцины дараах дархлааны идэвхи шалгах тандалт шинжилгээнд дээж цуглуулах ажлын удирдамжын дагуу Сүхбаатар, Хушаат, Орхон сумдын 60 өрхийн нийт 780 толгой малаас дээж цуглуулж, дээж авсан сум, өрхийн байршлын солбилцол, туулсан замналыг GPS багаж ашиглан тэмдэглэж, дээж авсан мал бүрийн бүртгэлийн цахим хэлбэрт оруулсан. Мөн аймгийн төвийн худалдаа үйлчилгээний газруудад борлуулагдаж буй мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болох адууны махны 3 дээж, 369 кг, үхрийн махны 57 дээж 7239 кг, хонины махны 127 дээж 2920 кг, сүүний 108 дээж 3340 л, дайвар 9 дээж 270 кг, өндөгний 225 дээж 3989 ш дээжинд тус тус МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийн баталгаажуулж гэрчилгээ олгов.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Аймаг сумын төсвийн байгууллага болон ОНӨААТҮГ-ийн хөрөнгийг нүдээр үзэн тооллого явуулж илүүдэлтэй ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгүүдийг ангилан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулж эд хөрөнгөд үнэлгээ тогтоолгон ажиллаа. аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын бага танхимд 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдөр нийтийн дуудлага худалдааг хуульд заасан журмын дагуу явуулж 7 дугаар сарын 14-ний өдрийн дотор дуудлага худалдаагаар худалдаалагдсан үндсэн хөрөнгүүдийн худалдан, худалдан авах гэрээг хийж ажиллалаа.

2017 оны 7 дугаар сарын 01-25-ны хооронд шинээр 4 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, үнэлгээний шатанд 2 төсөл арга хэмжээ, тендер ирүүлэх шатанд 2 төсөл арга хэмжээ, ТББ боловсруулж байгаа 1 төсөл арга хэмжээ байна. 50сая төгрөгний төсөвт өртөг бүхий Сүхбаатар суманд нийтийн тээвэр худалдан авах, 80 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах техникийн тодорхойлолтууд, 120,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Орхон сэлэнгийн бэлчирт үерийн хамгаалалтын далан барих ажлын төсөв ирээгүй тул тендер зарлагдаагүй 3 төсөл арга хэмжээ байна.

2.Байгаль орчны талаар:

Шаамар, Хүдэр, Ерөө, Мандал, Түшиг, Цагааннуур зэрэг сумдын санал болон ойгоос орох орлогын төлөвлөгөө зэргийг үндэслэн 2017 онд ойгоос нэмж мод бэлтгэх тухай тогтоолын төсөл боловсруулан аймгийн ИТХ-д өргөн барьсан.

Ойн хөнөөлт шавжийн хэт олшролтой Баруунбүрэн суманд 8000 га талбайд, Сант суманд 4000 га талбайд хийгдсэн ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь үзэж танилцлаа.

Ерөө сумын ашиглалтын бүсийн ойн санд хийгдэж буй ой зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийг хээрийн ажил хийгдэж байх үед тус газраас хяналт тавьж ажилласан. Уг ажлыг “Мөнх ногоон жодоо” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд хяналтыг тус газартай байгуулсан гэрээнд тусгагдсан зүйл тус бүрээр тулган шалгалаа. Тус компани нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд Ерөө сумын Ходоод орчимд байрлаж байхад газар дээр нь очин хяналт тавьж ажиллалаа.

Сумын болон сум дундын ойн ангиудыг чадавхижуулах зорилгоор “Ой зохион байгуулалтын хээрийн ажлын үзүүлэх сургалт”-ыг тус газар нь Ерөө сумын ашиглалтын бүсийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж буй “Мөнх ногоон жодоо” ХХК-тай хамтран зохион байгуулсан. Сургалтыг онолын болон практик хэлбэрээр явуулсан бөгөөд 50х50 харьцаатай 2 дээж талбай аван таксацын хэмжилт хийн тоон өгөгдлийг томъёонд оруулан дүнг тооцож ажилласан. Тус сургалтанд нийт 7 хүн оролцсон.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Зүүнбүрэн сум:

Ардын хувьсгалын 96, Зүүнбүрэн сум байгуулагдсаны 93 жилийн ой сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлж, гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээн болон өсвөрийн болон хүчит бөхийн барилдаан, сурын харваа, шагайн тус тус зохион байгуулсан. Баяр наадамд азарга 19, их нас 48, соёолон 23, хязаалан 37, шүдлэн -29, даага 38 нийт 194 хурдан хүлгүүд хурдаллаа. Мөн тус сумын уугуул Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Л.Баасанжавын нэрэмжит мото спортын улсын аварга шалгаруулах III гараа уралдааныг Зүүнбүрэн суманд амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн дахин санал хураалтын ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 5, эцэг тогтоолт 3, үрчлэлт 1, нас баралт 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 10, иргэний үнэмлэх гээгдүүлээд дахин авах 4, иргэний үнэмлэх олголтын 11 нийт 36 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

2017 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж буй “Зөрчлийн тухай хуулийн зурагт мэдээллийг мэдээллийн болон сурталчилгааны самбараар дамжуулан иргэдэд сурталчилж, “Соёл урлаг бидний хөгжилд” байгууллага сурталчлах өдөрлөгийн шилдэг номеруудын “Гала тоглолт”-ыг зохион байгуулж багийн дүнгээр Засаг даргын Тамгын газар 1 дүгээр байр, Үйлчилгээний байгууллагын хамт олон 2 дугаар байр, Бэлчир 2 дугаар баг 3 дугаар байранд тус тус шалгарлаа.

Сумын эрүүл мэндийн төвд 20 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулаториор 265 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 195, урьдчилан сэргийлэх үзлэгээр 255, диспансерийн хяналтаар 15, гэрийн идэвхтэй эргэлтээр 21, дуудлагаар 22 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны 395 иргэнийг элэгний С вирусын шинжилгээнд хамруулж С вирустэй 94, В вирустэй 20 иргэн оношлогдож дараагийн шатны эмнэлэгт баталгаажуулагдаж ажил хийгдэж байна. Артерийн даралт болон чихрийн шижингийн үзлэгт 23 иргэнийг хамрууллаа.

Хүнс Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй ажлын хүрээнд ургамал хамгааллын баг ажиллах болсонтой холбогдуулан “Одон буудай” ХХК-ний 320 га 320, “Шимт бүрэн” ХХК-ий 222 га талбайд судалгааны ажил хийгдлээ.

Төв аймгийн Загдал сумаас нүүдэллэн ирсэн малчин өрхийн 655 толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг газар дээр нь зохион байгуулж, хяналт тавин ажиллалаа.

Цагааннуур сум:

Сумын албан байгууллага аж ахуйн нэгжүүд, багуудын хэвийн үйл ажиллагааг хангахад удирдлага, арга зүйн зөвлөмж өгөн төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэн үйлчлэх, төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, сурталчлахад сумын Засаг дарга, түүний Тамгын газраас 2017 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажил, үйл ажиллагааны тайланг багуудын ИНХ-аар хэлэлцүүлэв. Сумын ЗДТГ-ын аппаратын хуралдааныг 2 удаа хийж, хуралдаанаар ажиллагсадын 2017 оны цалин тогтоолтыг шинэчлэн, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ээлжийн амралтын хуваарь, хийгдэх эрх зүйн сургалт, хөдөө багт “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. 2017 оны 07-р сарын 20-24-ны өдрүүдэд ЗДТГ-ын ажилтнууд хөдөө 2 багт “Иргэддээ хүрч ажиллая” уриатай

сумын ЗДТГ-ын даргын баталсан удирдамжын дагуу ажиллан нийт 622 иргэнд үйлчлэв.

2017 оны эхний хагас жилд сумын ЗДТГ-т удирдах дээд байгууллагуудаас 23 албан тоот, эрх зүйн баримт бичиг ирсэнийг бүртгэж, иргэд байгууллагад сурталчилан хэрэгжүүлж, биелэлтийг тооцон хариутай 10 албан бичгийн хариуг хугацаанд нь явуулж ажиллалаа. Үүнд: Аймгийн Засаг даргын захирамж 5, албан даалгавар 1, сумын ИТХ-ын тогтоол 1 тус тус ирсэн байна. Ирсэн бичгийг ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтан бүртгэлийн дэвтэрт бүртгэж Засаг дарга, удирдлагуудаар цохуулан ажилтнуудад тарааж хариутай албан бичгийн хариуг холбогдох албан тушаалтнуудаар гаргуулж хугацаанд нь явуулах арга хэмжээг авч ажиллалаа. Мөн сумын Засаг даргын А дугаартай захирамж 3, Б дугаартай захирамж 9, албан тоот 16, ЗДТГ-ын даргын тушаал 17 үүнээс А дугаартай 17, Б дугаартай 10, албан тоот 15 гарсныг бүртгэж биелэлтэнд хяналт тавин ажилласан. Сумын баяр наадмыг 2017 оны 07-р сарын 9-10-ны өдрүүдэд амжилттай тэмдэглэн өнгөрүүлэв.

Төвлөрсөн санд 47 аж ахуйн нэгж байгууллагаас 303703,1 мян төгрөг, 344 сайн дурын даатгуулагчаас 41362,2 мян төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 212 иргэнээс 12323,3 мян төгрөг тус тус хуримтлуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 373 өндөр настанд 601033,5 мянган төгрөг, 67 тэжээгчээ алдсан иргэнд 96240,1 мянган төгрөг, 201 тахир дутуу иргэнд 275793,1 мянган төгрөг, 4 цэргийн өндөр настанд 12270,1 мянган төгрөг, ҮОМШӨДаатгалын сангаас 5 иргэнд 7851,8 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 77 даатгуулагчдад 7244,9 мянган төгрөг, жирэмсэн, амаржсан 22 эхэд 16038,5 мянган төгрөг, -оршуулгын тэтгэмж 5 иргэнд 5000,0 мянган төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагч 62 иргэнд 15663,1 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

2017 оны 07-р сарын 22-ны байдлаар өссөн дүнгээр татварын орлого улсын төсөвт 25 471.0 мянган төгрөг оруулахаас 98 779.4 мянган төгрөг буюу 387.8 хувь, аймгийн төсөвт 138550.0 мянган төгрөг оруулахаас 103771.6 мянган төгрөг буюу 74.9 хувь, сумын төсөвт 45693.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 32915.4 мянган төгрөг буюу 75.5 хувиар биелүүлэв. 2017 оны хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, 2018 оны төсвийн төслийг боловсруулан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

2017 оны 7-р сард байгаль орчны албанаас нийт 911 иргэнд түлээний модны гоожин бичиж нийт 1924.0 мянган төгрөгийн орлого оруулав. Энэ сард 4 удаа хяналт шалгалт хийн, хуурайшилт байгаа энэ цаг үед амралт зугаалгаар явж буй 142 иргэнтэй уулзан ус, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар санамж бичиг тараав.

Баянгол сум:

Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, төр, төсвийн байгууллагаас 2017 оны 07 дугаар сарын байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Сумын үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээг төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, уг баяр наадмын нээлтийн урлагийн арга хэмжээнд Соёлын төвийн дэргэдэх Бадралбуян багш бүжгийн дугуйлангийн суралцагчид, сумын ардын авъяастнууд оролцсон.

2017 оны 07 дугаар сарын 17-ны өдөр сумын ЗДТГ-ын иргэний танхимд ногоочдын төлөөлөл нийт 28 иргэнийг хүлээн авч, зам дагуу байрлах лангууны хуваарилалт болон өөрсдөө ногоогоо тарьдаг болон бөөний цэгээс нийлүүлдэг ногоочдыг тус тусдаа үйл ажиллагаа явуулах, мөн зохион байгуулалтанд орж, намрын ногоочдын үзэсгэлэн худалдаанд сумаа төлөөлж оролцох тухай зөвлөгөө өгч, санал бодлоо солилцсон.

Тус сум нь Нидерланд улсын HRIF олон улсын хүмүүнлэгийн байгууллагатай 4 жил хамтран ажиллах гэрээг амжилттай байгуулсан бөгөөд уг гэрээ нь Монгол Улсаас зөвхөн Баянгол сумтай хийснээрээ онцлог болсон. Гэрээний дагуу сумын айл өрхийг ядуурлаас гаргах цаашлаад ЭМТ-д шаардлагатай тоног төхөөрөмжөөр туслахаар боллоо.

Сумын татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 2017.07.21-ний байдлаар сарын төлөвлөгөө 69,3 хувь, өссөнөөр 107,6 хувийн биелэлтэйгээр байна. Аж ахуйн нэгж, байгууллагын 2-р улирлын татварын тайланг 172 хуулийн этгээдээс цахим системээр хүлээн авч 100 хувь дуусгаж, 2018-2020 оны татварын орлогын төлөвлөгөөний төслийн саналыг төрийн санд хүргүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын санд нийт 30,5 сая төгрөгийн орлого орж Сэлэнгэ аймаг нийгмийн даатгалын хэлтсээс 221,2 сая төгрөгийн санхүүжилт авч 3 төрлийн тэтгэвэрт нийт 221,2 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Ажилгүйдлийн тэтгэмжид 4 хүнд 1,7 сая төгрөг, Жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 хүнд 860,0 төгрөг олгосон. Оршуулгын тэтгэмжинд 3 хүнд 3,0 сая төгрөг тус тус олгосон. Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн талаар багийн Засаг дарга нартай хамтран 94 иргэнд шинэчлэгдсэн хуулиар мэдээлэл хийж сурталчлан ажиллалаа.

2016-2017 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролыг 74, суурь боловсролыг 58, бага боловсролыг 78 сурагч тус тус эзэмшсэн төдийгүй насан туршийн боловсролоор 16 сурагч суурь боловсрол эзэмшсэн байна.

Бүрэн дунд боловсролыг 74 сурагч эзэмшсэнээс 46 сурагч буюу 62,1% нь улсын их, дээд сургуульд, 19 сурагч буюу 25,6% нь хувийн хэвшлийн их, дээд сургуульд, 9 сурагч буюу 12,1% нь гадаадын их, дээд сургуульд элсэн суралцахаар болсон байна.

Сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгээр нийт 548 иргэнийг хамруулж дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээж, хүлээн авах хэсгээр 435 иргэнд өдрийн эмчилгээ болон сувилахуйн тусламж үзүүлж, түргэн тусламжийн 196 дуудлага хүлээн авч үйлчилснээс алсын 59 ойрын 137 дуудлага авто ослын 12 дуудлаганд явж тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан. Эх хүүхдийн эрүүл мэнд-хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-2 насны 133 хүүхдэд ОНБТХ уулгасан. Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд одоогийн байдлаар 40-65 насны 820 гаруй иргэнийг хамруулснаас элэгний В вирустэй 68, С вирустэй 71 иргэн илэрсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 394 тоот тогтоолын дагуу малчин, мал бүхий иргэдийн улсын үйлдвэрт тушаасан хонины ноосонд урамшуулал олгох журмын дагуу малчид, мал бүхий иргэдийн ноосны материалыг авах ажлыг эхлүүлсэн бөгөөд 07-р сарын 24-ний байдлаар нийт 105 малчин, мал бүхий иргэн ноосны падааныг хүлээж аваад байна.

Сум хөгжүүлэх сангийн зөвлөл хуралдаж 12 төсөл ирснээс 5 төсөл шалгаруулан 75 сая төгрөгийн зээлийг гэрээ хийн олгоод байна.

Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу зөвшөөрөлгүй алтны агууламжтай чулуу бутлах 4 тээрмийн үйл ажиллагааг зогсоон лац тавьж битүүмжлэх, сумын ЗДТГ-ын урдуур байрлах хайлаас, шар хуайс моднуудыг тайрч тэгшлэн хэлбэржүүлж хортон шавжаас сэргийлэх, устгах зорилгоор хор цацах ажлыг тус тус хийлээ. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан эрхийн бичиг буюу элс, хайрга, чулууг ахуйн хэрэгцээнд ашиглах 5 иргэн, барилга байгууламжинд ашиглах 2 аж ахуй нэгжид 4 тн элс, 324 тн голын хайрга бэлтгэхэд хяналт тавьж, 812,0 мян төгрөгийн төлбөрийг орон нутгийн орлогод оруулсан.

Газрын тухай багц хууль тогтоомжууд, үл хөдлөх хөрөнгийн тухай хуулийн талаар 80 иргэнд заавар зөвлөгөө өгч, 33 иргэнд газар өмчлөх гэрчилгээний материал, 14 иргэнд байшингийн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авах материал бэлтгэн өгч ажиллалаа.

Тайлант сард шинэ төрсөн 10, гэрлэсэн 5, нас барсан 5, эцэг тогтоолт 7, иргэний үнэмлэх олголт 36, 16 нас хүрч иргэний үнэмлэх шинээр авах 9, 25,45 насны сунгалт хийлгэх 19 иргэн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн байна. Шилжин явсан 10, шилжин ирсэн 5 иргэн байна. Үл хөдлөх эрхийн гэрчилгээ 1, газрын гэрчилгээ 3 иргэнд бүртгэлийн дэвтэр хөтлөн олголоо.

Сайхан сум:

Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ой, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 08-09 –ны өдрүүдэд зохион байгуулж, нээлтийн үйл ажиллагаанд сумын төр, төсөв, хувийн хэвшлийн 20 гаруй байгууллага, аж ахуйн нэгжийн 350 гаруй ажилтан албан хаагчдын баярын

жагсаал боллоо. Мөн Дархан-Уул аймгийн 330 дугаар Цэргийн ангийн Цэрэг эрс хүрэлцэн ирж Нээлтийн туг залах үйл ажиллагаанд оролцсон байна. Баяр наадмын үеэр Төрийн өндөр шагнал болох “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор Ж.Циеэнхүү, Б.Ширчинжав, “Алтан гадас” одонгоор Б.Замбалгарав, М.Энхтуяа, М.Хишигсүрэн, Ц.Тунгалаг, М.Басан, Э.Дэлгэртуяа, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар Б.Буян нар шагнагдсаныг гардуулан өглөө. Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 64 бөх хүч үзэн барилдаж 5-ын даваанд сумын начин О.Төрбат, аймгийн харцага Ж.Мандахбаяр, н.Баатар нар үлдэж сумын начин О.Төрбат түрүүлэн “СУМЫН ЗААН” цол хүртэж, аймгийн харцага Ж.Мандахбаяр үзүүрлэлээ. Үндэсний сурын харваанд нийт 12 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдөж М.Дархатулга тэргүүн байр, М.Энхтулга дэд байр, Т.Мөнх-Эрдэнэ гутгаар байр эзэллээ. Мөн хүүхдийн сурын харваанд эрэгтэйчүүдийн төрөлд Б.Мөнх-Эрдэнэ тэргүүн байр, Б.Өсөхбаяр дэд байр, М.Анударь гутгаар байранд шалгарсан бол эмэгтэй төрөлд М.Наранчимэг тэргүүн байр, Э.Эрдэнэчимэг дэд байр, О.Дэлгэрмаа гутгаар байранд тус тус шалгарлаа.

Үндэсний шагайн харвааны тэмцээнд нийт 6 багийн 50 гаруй харваачид оролцож багийн харвааны төрөлд Батбаатар ахлагчтай баг тэргүүлж, Аюушбаатар ахлагчтай баг 2-р байр, Пүрэвдорж ахлагчтай баг 3-р байрт тус тус шалгарсан бөгөөд цуваа харвааны төрөлд н.Отгонбаатар тэргүүн байр, н.Хатанбаатар дэд байруудыг тус тус эзэллээ.

06-р сарын 29-30-ны өдрүүдэд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас Сайхан, Сант, Баруунбүрэн, Орхон, Орхонтуул сумдын “Хүүхэд хамгааллын хамтарсан баг”-т Хүүхэд хамгааллын чиглэлээр 2 өдрийн сургалт явуулж, сумын “Хүүхэд хамгааллын хамтарсан баг”-ийн гишүүд идэвхтэй оролцлоо.

Сайн дурын даатгалын хамрагдалтын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, үйлчилгээг сайжруулах зорилгоор Япон улсын “ЖАЙКА”-аас Токиогийн их сургууль, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулж буй судалгааны сургалтыг 07-р сарын 20-ны өдөр зохион байгуулан ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, газар тариалан эрхлэгч, оюутан зэрэг 40 гаруй иргэнийг хамруулав. Мөн сарын 24-ний өдөр Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Зүүнхараа ОНХХөтөлбөртэй хамтран 2018-2020 оны Үндэсний Стратеги Хөгжлийн Төсөл Хөтөлбөрийг зохион байгууллаа.

Элэгний өвчлөл, хавдраас сэргийлэх зорилгоор ЗГ-аас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд манай Сайхан суманд 2017 оны 06 сарын 17-с эхлэн 40-65 насны иргэдийг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 1140 хамруулснаас 98 хүн “В”, 148 хүн “С” вирустэй илэрсэн байна. 2017 оны 07-р сарын 21-ний өдрөөс эхлэн элэгний “В” вирустэй иргэдийн ар гэрийн эрүүл гарсан 40-65 настай иргэдэд “В” вирусын халдвараас сэргийлэх вакцины эхний тунг авч эхлээд байна. “Сүрьеэгүй Сэлэнгэ ” хөтөлбөрийн хүрээнд 06-р сарын 17-21-ний өдрүүдэд аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, ХӨСҮТ-тэй хамтран “ Уушигны эмгэг илрүүлэх үзлэг” шинжилгээг хийж судалгаагаар 739 хүн хамруулахаас нийт 819 хамруулж 117 хүн нь өөрчлөлттэй илэрсэн ба үүнээс уушигны сүрьеэ-2, архаг бронхит-46, гялтангийн үрэвслийн улмаас наалдац үүссэн-5, уушигны эдийн эмгэг өөрчлөлттэй-56, зүрхний эмгэгтэй-7 илэрсэн ба эдгээрээс 36 хүнээс цэрний шинжилгээ авч шинжилснээс 2 нь эерэг гарч 1 хүнийг Сэлэнгэ аймгийн Сүрьеэгийн тасагт хэвтүүлэн, 1 хүнийг гэрээр эмчилж байна.

“Цусны Донорын Дэлхийн Өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 7 хоногийн аяныг зохион байгуулж, сайн дурын цусны донорыг нэмэгдүүлэх зорилгоор албан байгууллага , аж ахуйн нэгждэд донорын сургалт сурталчилгаа хийж 24 хүнээс донор сонгох асуумж бөглүүлэн танилцснаас 11 хүнийг шинжилгээнд хамруулан, шинээр 2 цусны донор нэмж, одоогийн байдлаар нийт 18 цусны донортой болов.

Сумын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулан явуулж “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье” шилжин явах цом арга хэмжээний хүрээнд байгууллагын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд уг үйл ажиллагааны хүрээнд байгууллагын эмч мэргэжилтэн ажилчдад “Зөрчлийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулж, нийт 43 хүн хамрагдсан.

Сумын хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа явуулдаг 37 иргэн 31 аж ахуй нэгж байгаагаас энэ онд улаан буудай 13291 га, Рапс- 2066 га, төмс хүнсний ногооны үйл ажиллагаа явуулдаг 145 иргэн, 5 аж ахуй нэгж байгаагаас энэ онд төмс- 256 га, хүнсний ногоо- 236 га-д тариалсан дүнтэй байна.

Орхонтуул сум:

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймаг, сумын нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийн заалт, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёрдахь санал хураалт, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хөтөлбөрийн журам болох 39-өөс доош насны 2 гишүүнтэй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, хонин толгойд шилжүүлсэнээр 200 хүртэлх малтай гэсэн шаардлагыг хангасан Рашаант тосгоноос А.Наадамбаяр, Баянцогт 2-р багаас Б.Отгонбаяр, Б.Амартайван, Б.Энхсайхан, Ц.Мөнхбаяр, Хонгор овоо 3-р багаас О.Гантулга, Ц.Ганхүү гэсэн залуу малчдыг хамруулж тус бүр 4-5 тугалтай үнээ авч өгөх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Тухайн сард Эрүүл мэндийн даатгалд-12 хүн хамруулж, нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 07-р сарын 24-ний байдлаар 5252.89 мянган төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 737.2 мянган төгрөгний хураамжийн орлого орсон байна.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт - 351 хүнд-97105,7 мян төгрөг, Тахир дутуугийн тэтгэвэрт-124 хүнд-29000,47 мян төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 23 хүнд-5179,37 мян төгрөг, Цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр -1 хүнд 377.0 мян төгрөг нийт 136365,84 мян төгрөгийг тус тус тавьж олгосон.

ХЧТАлдсаны тэтгэмж-3 хүнд 956.5, Ажилгүйдлийн тэтгэмж 1 хүнд-164,24 мян төг нийт тэтгэмжинд 1120,79 мян төгрөг хугацаандаа олгогдлоо.

Энэ сард шинээр 5 хүүхэд төрсөн байна. Гэрлэлт-1, нас баралт-1, үрчлэлт-1, шилжиж ирсэн-1, шилжиж явсан-5 иргэний мэдээллийг үндсэн мэдээллийн санд оруулж бүртгэсэн байна. Иргэний цахим үнэмлэх шинээр-4, сунгалт-8, дахин-4, олголт-26 иргэнд цахим үнэмлэхний үйлчилгээ үзүүлж хэвлэгдсэн 26 цахим үнэмлэхийг шуурхай олголоо.

“Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ын дагуу 10 эх хүүхдэд хүндэтгэл үзүүлэн Засаг даргын гарын бэлэг өглөө.

Баруунбүрэн сум:

Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 106, Ардын хувьсгалын 96, Баруунбүрэн сумын 93 жилийн ойн Үндэсний их баяр наадам Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 2017 оны 7-р сарын 9,10-ны өдрүүдэд болж, нээлтийн арга хэмжээ тус сумын ЕБС-ийн сурагчдын урлагийн тоглолт болон албан байгууллага, ард иргэдийн хүндэтгэлийн жагсаалын арга хэмжээг зохион байгуулсан. Баяр наадмын хүчит бөхийн барилдаанд нийт 32 бөх барилдсанаас Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын начин Н.Алтангэрэл түрүүлж “Сумын Заан” цол, Баруунбүрэн харьяат А.Амархүү үзүүрлэж “Сумын начин” цол хүртсэн.

Тус сумын хэмжээнд уриншийн боловсруулалтыг 10782 га талбайд хийж, 2017 оны үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалтын мэдээг нэгтгэн иргэд, аж ахуй нэгж бүрээр ХАА-7 Б маягтын дагуу гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Мөн сумын хонь, ямааны ангилалтын материалыг аймгийн ХХАА-н газарт хүргүүлсэн ба сумын дүнгээр 5000 хонь, 1500 ямаа хамрагдсан. Мөн царцааны устгал хийх газрын судалгаа, талбайн хэмжээг гаргаж 1 дүгээр багт 2000 га талбай, 2 дугаар багт 3000 га талбай бүхий Хуучин төв, Бумбат, Жаргалант, Оорцог, Шувуут, Урт, Зүүвч, Хүж гэсэн газрыг хамруулахаар аймгийн ХХААГ-т хүргүүллээ.

Мал төллөлтийн мэдээ, том малын хорогдлын мэдээг тус тус гаргаж аймгийн статистикийн хэлтэст хүргүүллээ. Одоогийн байдлаар 59851 толгой хээлтэгч төллөж 59851 төл гарч, 1463 төл хорогдож 58388 толгой төл бойжиж байна. Үүнийг малын төлөөр нь авч үзвэл гүү-1724, ингэ-3, үнээ-3522, эм хонь-33860, эм ямаа-20742 төлөлж унага-123, тугал-120, хурга-540, ишиг-680 толгой тус тус хорогдож ботго-3, унага-1601, тугал-3402, хурга-33320, ишиг-20062 толгой тус тус бойжиж байна.

Сумын хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сохор догол өвчний вакциныг бог-3600 толгой, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг унага, даага-760 толгой, цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 920 толгой үхэрт, гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 100 толгой гахайнд нийт давхардсан тоогоор 5380 толгой мал амьтанд хийж гүйцэтгэсэн.

"Сайхан ойн төлөө" ХХК-тай хамтран гэрлэн урхиар ойн хортон шавьжтэй тэмцэх тэмцлийн ажлын судалгаа хийн тухайн тэмцлийн ажил явуулах ойн санг эзэмших нөхөрлөлүүдэд мэдээлэл өгсөн. Хушаат сумын "Өнө-Орших булаг" ХХК-д Тойлбод, Сант сумын Тэлт, Баянзүрх хэмээх газарт, Сайхан сумын "Хэт Жолоо" ХХК-д Зүүвчийн аманд тус тус талбай тусгаарлалтыг хийсэн.

Сумын эрүүл мэндийн төв байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээг энэ сарын 22, 23-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 200 гаруй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж баярын хуралд оролцон Эрүүл Мэндийн төвийн дарга болон сумын Засаг дарга, ИТХ-н дарга нар 15 гаруй ажилчдад шагнал гардуулсан. Мөн анхны эмч С.Доржийн үр хүүхдүүд болон бусад ахмад ажилтнуудаас кварц, тэргэнцэр, нярайн жин, хүчилтөрөгчийн аппарат, пүлс оксометр, авто клав болон бусад мөнгөн хандив тусламж үзүүлсэн ба аймгийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн дотор өрөө палат, халдварт, төрөх, амбулатори, больницийн хэсгүүдэд их засвар хийж, эмнэлгийн гаднах зам талбай, саад, хашаа, саравч зэргийг засварлаж тохижуулах ажлыг хийлээ.

2017 онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн засварын ажлыг Дархан-Уул аймгийн "Ноён-Өндөр" ХХК гүйцэтгэж байна.

Шаамар сум:

"Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 6 өрхийн 36 гишүүнд 2017 оны 7 дугаар сарын талон болох 46 ширхэг үнэт цаас бүхий 29900 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлойд" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа."Нийгмийн халамжийн тухай хууль"-ийн дагуу байнгын асаргаа шаардлагатай иргэдийн байнгын асаргааны хугацааг сунгах болон шинээр хамрагдах хүсэлт өгсөн 4 иргэний гэрт "Амьжиргаа дэмжих зөвлөл"-ийн гишүүдтэй хамт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

2017 оны 7 дугаар сарын байдлаар Шаамар сумын 1,2 дугаар багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй 1, эмэгтэй 2 хүүхэд төрж, нийт 3 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгосон. Гэрлэлтээ батлуулсан 1, нас барсан 1, иргэний гэрчилгээг тус тус олголоо.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2010 оны 315 дугаар тушаалаар "Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах журам"-ын дагуу 2015 оны 05 дугаар сарын байдлаар шинээр иргэний үнэмлэх авах 2, ба 25,45 насны сунгалт хийлгэх 9 иргэний хүсэлтийг үндэслэн маягт 8/ИУБ-31/-ыг цаасан болон цахим хэлбэрээр CD-нд хуулбарлан баталгаажиланд хүлээлгэн өгсөн. Дахин авах хүсэлт гаргасан 2 иргэний материалыг бүрдүүлсэн. Хэвлэгдэн ирсэн 14 иргэний үнэмлэхийг иргэдэд тарааж ИУБ-21 бөглөн холбогдох газарт хүргүүлсэн. Шилжин ирсэн 3, шилжин явсан 4 иргэний хүсэлтийн дагуу шилжүүлгийг хийж ажиллалаа.

Монгол Улсын Ойн тухай хууль, Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, зэрэг хуулинд заасан эрх үүргийн талаар нийт 132 иргэнд танилцуулж, гарын авлага тарааж гарын үсэг зуруулж, гэрийн хаяг, холбоо барих утасны дугаар зэргийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж хаврын хуурайшилтын үеэр ой хээрт зорчиж зугаалахгүй байхыг сануулж

зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох хуулийн зүйл заалтыг сануулсан. Мөн Ойн тухай хууль, Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль зэрэг хуулийн хэрэгжилтийн хүрээнд эргүүл хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж сумын нутаг дэвсгэрт Цагдаагийн алба хаагч болон Байгаль хамгаалагчийн хамтаар шөнийн цагаар нийт 21 удаа хийсэн ба эргүүл хяналт шалгалтаар илрүүлсэн болон иргэдээс ирсэн мэдээллийн дагуу Түгээмэл тархацтай ашигт малтмалын болон Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн 2 зөрчилд нийт 2,450,000 төгрөгний торгуулийг ногдуулж 100 хувь барагдуулсан.

Сүхбаатар сум:

Сүхбаатар сум байгуулагдсаны түүхт 80-н жилийн баяр наадам 2017 оны 07 дугаар сарын 28-аас 30-ны өдрүүдэд хүн зон ихтэй, хүчит бөх бянтай, хүлэг морьд хурдан, цэц магнай тэгширсэн сайхан наадам болж өндөрлөлөө. Баяр наадмын нээлтийн арга хэмжээг МУСТА Б.Амарсайхан найруулж, нисдэг загварын онгоц, 80-н морин хуурч, 30 гаруй бүжигчид, 300 авъяаслаг хүүхдүүдийн гимнастик, морины гайхамшигт үзүүлэх тоглолт, цэргийн парад, байгууллагуудын жагсаал гээд олон сайхан арга хэмжээнүүд болсон. Баяр наадмын хүчит бөхийн барилдаанд 128 бөх барилдсанаас Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат Г.Эрхэмбаяр аварга түрүүлж, Мандал сумын харьяат улсын заан Н.Жаргалбаяр үзүүрлэн хурсан олныг цэнгүүлж, хурдан морины уралдаанд нийт 9 насны 700 гаруй морьд шандас хурдаа сорьж наадамжчин олноо баясгалаа. Жороо морьдын уралдаан болж Хонгор морьтын 1-р багийн Т.Энхтөрийн хүрэн халзан азарга 4 дэх түрүүгээ авлаа. Сурын харвааг үндэсний, буриад, урианхай гэсэн 3-н төрлөөр 100 гаруй харваачид эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны хүүхдүүдийн дунд зохион байгууллаа. Үндэсний сурын эрэгтэй харваанд Орхон аймгийн харваач Л.Эрдэнэбат тэргүүн байр, Т.Түвшинтулга дэд байр, П.Гармаа гуравдугаар байрыг, эмэгтэй үндэсний сурын харваанд Орхон аймгийн М.Мөнх-Амгалан тэргүүн байр, Улаанбаатар хот Д.Норжмаа дэд байр, Төв аймгийн С.Өлзийжаргал гуравдугаар байр, хүүхдийн эрэгтэй сурын харваанд Орхон аймгийн С.Цэнд-Аюуш тэргүүн байр, Улаанбаатар хотын Б.Маргад-Эрдэнэ дэд байр, Төв аймгийн Б.Төгөлдөр гуравдугаар байрын шагналыг тус тус хүртлээ.

Шагайн харваа тэмцээн ахмад болон залуучуудын насны ангилалаар зохион байгуулагдаж нийт 70 гаруй харваачид цэц мэргэнээ сорилоо. Ахмад насны ангилалд төмөр замын баг тамирчид тэргүүн байр, Хөтөл хотын баг дэд байр, Мандал сумын баг тамирчид гуравдугаар байрыг эзэллээ.

Түүхт 80-н жилийн ойг угтан Цагаан эрэгийн 2-р багийн Барилгын 27-р байрыг хэрэглээний халуун усны шугаманд холбох, Бор гүвээ 5-р багт тоглоомын талбай байгуулах, Орхоны 6-р багийн Шар 5 давхарын 11,12,13-р байрны дунд тоглоомын талбай байгуулах, Г.Бумцэндийн нэрэмжит 1-р сургуулийн дотуур байрны засвар, Ган зам 7-р багийн 60-н айлуудын дунд тоглоомын талбай байгуулах, Төв замын засвар, замын тэмдэг тэмдэглэгээ, Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын гадна трасны өргөтгөл, Хонгор морьтын 1-р багт байрлах Сүхбаатар сумын гэрэлт цогцолборын засвар, Ган замын 7-р багийн төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах, дулаан хувиарлах төвийн засварын ажлууд болон цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төсвийн төлөвлөгөөний дагуу аймгийн төсвөөс 269,734,300 төгрөгийн татаас авч орон нутгийн төсөвт байгууллагуудад 541,647,500 төгрөгийн санхүүжилт өгөх төлөвлөгөөтэйгээс 528,198,290 мянган төгрөг олгогдсон бөгөөд 7-р сарын өссөн дүнгээр санхүүжилт 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна. 2017 оны орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулсан бөгөөд орон нутгийн орлогын гүйцэтгэл 7-р сарын гүйцэтгэлээр 115,9 хувьтай төвлөрсөн байна. Хүү торгуулийн орлого, үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж зэрэг орлогууд 131-181 хувиар давж биелсэн ба бууны татвар 54,85 хувийн биелэлттэй хөрөнгө борлуулсны орлогын татвар 48,8 хувийн биелэлттэй байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас 14 хоногт 1 удаа дотоодын сургалт зохион байгуулж хэвшсэн бөгөөд тайлант сард албан хаагчдад салбарын эрх зүйн актуудад танцууллаа. Эрх зүйн хөтчөөр дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, гарын авлага сурталчилгааны материалаар хангаж, 30 гаруй өрхийн 80 гаруй хүнд эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн онцгой байдлын газраас ирүүлсэн "Ой хээр болон орон байрны түймрээс сэргийлцгээе" уриалгыг хэрэгжүүлж, сумын ЗДТГ-н 19 ажилтан графикийн дагуу түймрийн жижүүр гарган ажилласан. Мөн "Гол мөрний усанд осолдохоос сэргийлье", "Ой хээрийн түймрийн аюулаас сэрэмжилье", Нуур цөөрөм гол мөрөн бүхий газраар бага насны хүүхдийг хараа хяналтгүй явуулахгүй байхыг анхааруулж байна.

Үндэсний статистикийн хорооноос батлагдсан хуваарийн дагуу 2017 оны 02-р улирлын тайлан мэдээг сумын хэмжээнд түүвэрлэгдэж ирсэн нийт 64 аж ахуй нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулсан.

2017 оны эхний 7 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэн 427 байсан бол 105 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 92 ажлын байранд 72 иргэн ажилд зуучлагдан, идэвхгүйн улмаас 83 иргэн хасагдаж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 377 болсон байна. Шинээр 190 ажлын байр бий болгохоос, хагас жилийн байдлаар 79 ажлын байр шинээр бий болсон нь 41,7 хувийн биелэлттэй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд нийт 37 иргэнийг хамрууллаа. Үүнд: Ганцаарчилсан зөвлөгөө 37 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих жижиг зээлийг "Голомт банк"-аар дамжуулан 3 иргэн аж ахуй нэгжид 47000.0 мянган төгрөгийн зээлийг олгож, шинээр 9 ажлын байр бий болгож бүртгэж мэдээллэлээ.

Эзэмшиж буй газраа өмчлөхөөр 12 иргэн хүсэлт гаргасанаас 8 иргэний өргөдлийг бүртгэн Сэлэнгэ аймгийн газрын албанд хүргүүлж, багийн Засаг дарга нарт 7-р сарын 12-ны өдөр "Газрын тухай багц хууль"-ийн хүрээнд 8-н төрлийн гарын авлага бэлтгэн тараасан.

Иргэдээс сумын Засаг дарга болон түүний Тамгын газарт 2017 оны 07 дугаар сарын байдлаар 12 өргөдөл ирүүлснээс газрын тухай-2, асран хамгаалагч тогтоох тухай-2, Зөрчил арилгуулах тухай-1, бусад -7 өргөдөл, гомдол хүлээн авч өргөдөл гомдлын шийдвэрлэлт 97 хувьтай байна.

Жавхлант сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 1, байгууллагын өргөтгөсөн шуурхай хурал 3, албан хаагчдын хурал 1 удаа хуралдлаа.

Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын 96 жилийн ой, Жавхлант сум байгуулагдсаны 40 жилийн ойн баяр наадам, сумын ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, эрүүл мэндийн төв, 26-р цэцэрлэгийн 40 жилийн ойн баярын арга хэмжээг тус тус амжилттай зохион байгууллаа.

Ойн баяр наадмаар Монгол Улсын Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор- 2, Алтан гадас одонгоор- 4, Хөдөлмөрийн хүндэт медаль-5, Хүнс хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан-9, Хөдөлмөрийн тэргүүний ажилтан-2, Хүнс хөдөө аж ахуйн "Жуух бичиг" 2, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын "Хүндэт ажилтан"-аар 1, Боловсролын тэргүүний ажилтнаар 3, "Ахмад зүтгэлтэн багш" 2, "Хүндэт ажилтан" 2, "Багшийн гавьяа" одонгоор 1, Боловсролын яамны "Жуух бичиг"-ээр 2, Худалдаа үйлчилгээний тэргүүний ажилтан цол тэмдгээр 1, "Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр 1, "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан" цол тэмдгээр 3, "Онц тээвэрчин" цол тэмдгээр 2, Монголын Залуучуудын холбооны "Цэргийн алдар" цол тэмдгээр 1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хүндэт тэмдгээр 1, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хүндэт "Жуух бичиг"-ээр 1, аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр 12, сумын Засаг даргын "Жуух бичиг"-ээр 12, Монголын Нүүдэлчин малчдын үйлдвэрлэл биенесийг дэмжих сангийн Улсын сайн малчин одонгоор 2, сумын алдарт уяачаар 3 иргэн тус тус шагнагдлаа.

Орон нутгийн татварын орлогод 07-р сарын байдлаар 17215,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 20592.6 мянган төгрөг төвлөрүүлж, 119,6 хувийн биелэлттэй байна.

Аймгийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 5 ажил бүрэн хийгдэж аймгийн комисс хүлээн аваад байгаа ба 102,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Монгол Улсын хаягжилтын тухай хууль, Засгийн газрын 280-р тогтоолоор батлагдсан гудамж талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журмын дагуу 130 айл өрхийг хаягжуулж, газар эзэмших болон газраа шилжүүлэх хүсэлт гаргасан 7 иргэний материалыг хүлээн авч шийдвэрлэж, 2017 оны уринш боловсруулалтын ажлыг 6000 га-д хийгээд байна.

Улаанбаатар хотод шүлхий өвчин гарсантай холбогдуулан сумын Засаг даргынз ахирамж гарч Жавхлант 3 замын уулзвар дээр ариутгалын постыг 5 хоног ажиллууллаа.

Энэ сард шинэ төрсөн 6, эцэг тогтоох 4, гэрлэлтээ бүртгүүлсэн 3, иргэний үнэмлэх олголт 14, иргэний үнэмлэх гээгдүүлсэн 3, үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах, хугацаа сунгуулах 3, шинээр иргэний үнэмлэх захиалсан 8 нийтдээ 41 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, мэдээллийн санд шивлээ.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төв нь нийт 230 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 57, амбулаторын үзлэг 42, идэвхитэй хяналт 50, гэрийн идэвхитэй үзлэг 81 хийж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч ажиллалаа. Дархлаажуулалтанд товллын дагуу 21 хүүхдийг хамруулан зөвлөгөө өглөө.

Хушаат сум

Сумын 30 жилийн ойн баяр наадмыг энэ сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сумын 30 жилийн ойн баяр наадмын хүчит бөхийн барилдаанд 218 бөх барилдан үүнээс улсын цолтой 5, аймгийн цолтой 24 бөх байснаас Улсын начин Чотонгийн Баянмөнх, аймгийн арслан Мөнхбаяр, аймгийн заан 5, харцага 3, начин 7 барилдсанаас улсын начин Чотонгийн Баянмөнх үзүүрлэн сумын заан Халтарын Чинбат түрүүлээ. Шигшээ 32 бөхийн барилдаанд Хушаат сумын Д.Цэрэнсодном, Г.Чинбат, Цэдэн-иш, Сант сумын Бямбацогт нар шөвгөрч Д.Цэрэнсодном, түрүүлэн Г.Чинбат үзүүрлэлээ. Өсвөрийн бөхийн барилдаанд 32 бөх барилдаж Зүүнхараа хотын ЕБС-ийн сурагч Ууганболд түрүүлэн Сайхан сумын сурагч Наранболд үзүүрлэн Хушаат сумын ЕБС-ийн сурагч Ц.Цэнгүүнбаяр, Зүүнбүрэн сумын сурагч Б.Бүрэнтөгс нар шөвгөрлөө. Баяр наадмын үндэсний сурын харваанд Сэлэнгэ аймгийн уугуул Сухбаатар сумын харьяат Г.Түвшинтулга түрүүлж Б.Алтанбагана, П.Гармаа/ Баян-өлгий аймгийн уугуул нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Алтан дуулга” багийн харваач үндэсний болон урианхай сурын спортын мастер/ А.Түмэнжаргал/ Дархан уул аймгийн мэргэн спортын мастер/ Т.Эндэнэ-очир / Орхон аймгийн харьяат Хангарьд спорт клуб Отгонтэнгэр ХХК-ийн харваач аймгийн мэргэн/ нар удаахь байрт шалгарлаа. Хүүхдийн төрөлд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ЕБС-ийн сурагч А.Түвшинсанаа, Ерөө сумын ЕБС-ийн сурагч М.Мөнхзаяа, Мандал сумын 3-р сургуулийн сурагч Д.Пүрэвбат нар эзэлж амжилт үзүүллээ. Наадмын хурдан морины уралдаанд азарга насанд Хушаатын Л.Банзрагчийн хонгор түрүүлэн Дарханы Орхон сумын Е.Цэвээн-очирын хээр, Барунбүрэнгийн А.Бямбахүүгийг цавьдар, Сантын И.Жамсранжавын бор, Хушаатын П.Бямбацэдэнгийн хар азарга айрагдаж, Их насанд Дархан уул аймгийн С.Энхтөрийн хээр түрүүлэн Хушаат сумын Д.Алтансүхийн хээр, Сант сумын С.Дэлгэрсуурийн хээр, Хушаат сумын Б.Эрдэнэхүүгийн соёмбо хул, Баруунбүрэн сумын Б.Ганболдын хүрэн айрагдаж, Соёолон насанд Жавхлант сумын Б.Хишигтогтохын саарал түрүүлэн, Хушаат сумын Д.Ариунболдын хонгор, Сайхан сумын Н.Тулгын хүрэн, Сүхбаатар сумын Д.Энхсүхийн хээр алаг, Орхон аймгийн Баян-өндөр сумын Б.Ядамсүрэнгийн хүрэн айрагдлаа. Хязаалан насанд Баруунбүрэн сумын Э.Ариунболдын хээр түрүүлэн Хушаат сумын Төрмандахын хээр, Цагааннуур сумын Батцогтын хонгор алаг, Дархан уул аймгийн Орхон сумын В.Жавхланбаярын шарга, Дархан уул аймгийн Батжаргалын дада хээр, шүдлэн насанд Хушаат сумын Д.Алтансүхийн алаг түрүүлэн Алтанбулаг сумын Д.Эрдэн-очирын бор халдан,

Цагааннуур сумын Н.Цагаанхүүгийн хээр, Цагааннуур сумын Б.Алтангэрэлийн цавьдар, Сүхбаатар сумын аймгийн алдарт уяач Д.Баатарын хээр, Даага насанд Хушаат сумын Х.Чинбатын саарал түрүүлэн, Хушаат сумын уяач Б.Энхтүвшингийн хүрэн, Хушаат сумын уяач Б.Золхүүгийн сартай хүрэн, Баруунбүрэн сумын Б.Золбоогийн хээр, Баруунбүрэн сумын Бүрэнтогтохын хул даага тус тус айрагдлаа.

Сумын 30 жилийн ойг угтаж аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 80.0 сая төгрөгийн хөрөнгөөр Цэнгэлдэх хүрээлэн, морь барианы талбай, аймгийн замын сангийн 20.0 сая, сумын ОНХСангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн зам засварын ажил зэргийг хийж гүйцэтгэтгэж, “Хушаат нутгийн хөгжил сан”-ийн хөрөнгө, “Сэлэнгийн цагаан” ХХК-ийн 35.0 сая төгрөгийн хөрөнгөөр Ёслол хүндэтгэлийн өргөө, “Гачуурт” ХХК-ийн 28.0 сая төгрөгийн хөрөнгөөр ЗДТГ-ын урд бетонон талбай, “Артойлбо” ХХК-ийн 3,0 сая төгрөгийн хөрөнгөөр цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуур, “Хушаат уран төгөл” ХХК-ийн 2,5 сая төгрөгийн хөрөнгөөр сумын хилийн цэс дээр Хушаат самбар, сүүдрэвч, Хайрхан оргил уул ХХК-ийн 2,6 сая төгрөгийн хөрөнгөөр цэцэрлэгт хүрээлэн дэх амралтын сүүдрэвч хийсэн. Мөн Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн хөрөнгө оруулалтаар Хушаатын Усан сээрт дурсгалын хөшөө, сумын хуучин төвд САА-н суурин дээр дурсгалын хөшөө, Хөдөө хараат уулан дээр эмээ өвөөгийн дурсгалын хөшөө, “Хушаат нутгийн хөгжил сан”-гийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгөөр цэцэрлэгт хүрээлэнд ДТ-75 хөшөөний цогцолбор хөшөө, 14.0 сая төгрөгөөр “Хушаат сумын түүхийн хураангуй бичээс” ном, 10.0 сая төгрөгөөр баримтат кино, 4.9 сая төгрөгөөр Казакийн цагаан толгойи үүлдрийн бухны хөшөө, 6.0 сая төгрөгөөр хорооллуудын өнгө үзэмжийг сайжруулах ажил зэргийг хийлээ.

“Мерси кор” ОУБайгууллагаас хэрэгжүүлж байгаа “Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөр тус суманд хэрэгжихээр болж “Хушаатын баялаг” хоршоо шалгарч тус хөтөлбөрийн танилцуулга сургалт зохион байгуулагдаж 40 иргэн хамрагдлаа.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлд 30 байгууллага, аж ахуйн нэгжийн 132532,3 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 108 хүний 17829,7 мянгахн төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 176 хүний 9270,7 мянган төгрөгийн хураамжийг тус тус оруулжээ. Шинээр тэтгэвэр тогтоолгох 14 хүний, шилжин ирсэн 1 хүний материалыг бодож баталгаажуулан 22 хүнд тэтгэвэр тогтоолгох зөвлөгөөгч, өссөн дүнгээр 628 хүнд ЭМД, НД-ын сайн дураар даатгуулах зөвлөгөөг өглөө.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг ажил үйлчилгээний хүрээнд ажил олгогч байгууллага, иргэнээс сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч бүртгэн шинэ ажлын байранд 2 иргэнийг зуучиллаа. “Ойн цэвэрлэгээ” нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж ажилгүй болон зорилтот бүлгийн 20 иргэнийг хамруулж нийт 5600.000 төгрөгийн цалин олгож өрхийн орлогыг нэмэгдүүллээ. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 20 иргэнд өглөө. Хурдан морь унаач хүүхдүүд, эцэг эхчүүдэд зөвлөмж бэлтгэн тараалаа. Баяр наадмын хурдан морины уралдааны бай шагналын 20%-ийг хүүхдэд олгож хэвшээд байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд ЭМТ-ийн ор хоног 150, үзлэгийн тоо 108, хяналтанд байгаа жирэмсэн 15, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 80, түргэн тусламжийн дуудлага 42, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18 хүн, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт 18, умайн хавдар хөхний хавдар эрт илрүүлэг үзлэгт 5, элэгний эрт илрүүлэг үзлэгт 31 хүн хамрагджээ.

Энэ сард улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 2, овог нэр өөрчлөлт 2, шилжин явсны 1, шилжин ирсний 1, гэрлэлт цуцлалтын 1, нас барсны 1, цахим үнэмлэх дахин авах 2, биеийн давхцахгүй өгөгдлийн 3, газар өмчлөх эрхийн 1, иргэний үнэмлэх олголтын 12 нийт 26 бүртгэл хийж 9 гэрчилгээ бичиж олгожээ. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 17500, УБСГ-ын дансанд 92500 төгрөгийн орлого оруулж 2 иргэний гадаад паспортын сунгалтыг хийлээ.